

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН НЯМДОРЖИЙН ЛУВСАНШАРАВЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.”							
1.	Арга хэмжээ 1.1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулна.	Батлагдсан баримт бичиг	1	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг хуулийн хугацаанд батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	01-06	100
Зорилт 2. “Сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон яамны хэмжээнд албан болон ажлын айлчлал, гадаад томилолтыг зохион байгуулна.”							
2.	Арга хэмжээ 2.1. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын албан болон ажлын айлчлал, гадаад томилолтыг зохион байгуулна.	Зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0	10	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжлэх ухаан, технологийн яамнаас тус улсын “Бүс ба зам” санаачилгын хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 08-наас 12-ны өдрүүдэд Сычуань мужийн Чендү хотноо зохион байгуулах “Шинжлэх ухаан, технологийн хоёрдугаар бага хурал”-д оролцож, тус улсын дэлхийн хамгийн том дата төв болох Хөх хот дахь Өвөрмонголын мэдээллийн парк (China Telecom – Inner Mongolia	01-06	90

					Information Park)-ийн үйл ажиллагаатай танилцах уулзалтыг хийхээр төлөвлөн холбогдох бэлтгэл ажлыг ГХЯ болон тус улсын Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулахаар төлөвлөж Засгийн хуралдаанд танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажилласан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цуцлагдсан болно.		
3.	Арга хэмжээ 2.2. Яамны албан хаагчдын гадаад албан томилолтоор ажиллахад дэмжлэг үзүүлнэ.	Зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0			Тайлант хугацаанд гадаад улс орнуудад зохион байгуулсан арга хэмжээнүүдэд яамны албан хаагчдын гадаад албан томилолттой холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	01-06	90

Зорилт 3. “Олон улсын байгууллага, гадаад улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээрийн байгуулах бэлтгэлийг хангана.”

4.	Арга хэмжээ 3.1. Олон улсын байгууллага, гадаад улсын байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хэрэгжилтийн хувь	29	15	1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ын 8.2 дахь хэсэгт заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр хооронд 2025 оны 2 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан "Төсөл эхлүүлэх төлөвлөгөө, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр хооронд 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан "Санхүүжилтийн гэрээг" тус тус Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэв. 2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Франц Улсын "Талес Алениа Спэйс"	01-06	80
----	---	-------------------	----	----	--	-------	----

				компани хооронд 2023 оны 10 дугаар сард байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийг сунгасан тухай нэмэлт, өөрчлөлтийг өнгөрсөн 5 дугаар сард баталгаажуулсан тул Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу уг нэмэлт, өөрчлөлтийн хувийг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэв. 3. Тус яам болон Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран “Хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалтын Монгол Улс болон Оросын Холбооны Улсын харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн байгууллага хоорондын хоёр талт хуралдаан”-ыг Улаанбаатар хотноо 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулж, Монгол Улс, Оросын Холбооны Улсын харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн байгууллага хооронд Радио давтамжийн 29.7-470 МГц, 450 МГц, 150 МГц, 700 МГц зурваст газрын хөдөлгөөнт болон 29.7-39.5 МГц зурваст газрын хөдөлгөөнт бус үйлчилгээний зохицуулалтын асуудлаар нийт 4 гэрээг байгуулахаар тохиролцож, дипломат шугамаар баталгаажуулан Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэв.		
--	--	--	--	--	--	--

Зорилт 4. “Монгол Улсын гишүүнчлэл бүхий мэдээлэл, харилцаа холбооны салбарын олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох ажлыг зохион байгуулна.”

5.	Арга хэмжээ 4.1. Гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалт, арга хэмжээнд тэтгэлгээр оролцох хүсэлтийг баталгаажуулж хүргүүлнэ.	Тэтгэлэг хүссэн арга хэмжээний тоо	35	15	Гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалт, арга хэмжээнд яамны албан хаагчдын тэтгэлгээр оролцох хүсэлтийг холбогдох байгууллагуудад баталгаажуулан хүргүүлсэн.	01-06	90
6.	Арга хэмжээ 4.2. Гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалт арга хэмжээнд оролцуулна.	Оролцсон арга хэмжээний тоо	24	15	Гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалт арга хэмжээнд яамны албан хаагч хамрагдахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.	01-06	90

Зорилт 5. “Салбарын үйл ажиллагааны хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны урилгаар Монгол Улсад ирэх гадаадын төлөөлөгчдийн айлчлал зохион байгуулна.”

7.	Арга хэмжээ 5.1. Салбарын үйл ажиллагааны хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны урилгаар Монгол Улсад ирэх гадаадын төлөөлөгчдийн айлчлал зохион байгуулна.	Зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0	4	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урилгаар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр хамтран 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр “Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги” анхдугаар чуулганыг зохион байгуулсан. Тус чуулганд Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагуудаас оролцох Төлөөлөгчид нэрсийг хүлээн авч, илтгэгчээр уригдан оролцсон Төлөөлөгчийг угтах, үдэх ажлыг харьяа байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.	01-06	100
----	---	--	---	---	--	-------	-----

Зорилт 6. “Гадаад улс орнуудад зохион байгуулах мэдээлэл, харилцаа холбооны салбарын үзэсгэлэн, экспод төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулна.”

8.	Арга хэмжээ 6.1. Гадаад улс орнуудад зохион байгуулах мэдээлэл,	Арга хэмжээний тоо	1	1	Тайлант хугацаанд гадаад улс орнуудад зохион байгуулсан мэдээлэл, харилцаа холбоо технологийн салбарын арга		
----	---	--------------------	---	---	---	--	--

	харилцаа холбооны салбарын үзэсгэлэн, экспод төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцоход дэмжлэг үзүүлнэ.				хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцоход мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.		
Зорилт 7. “Олон улсын, бүсийн, гадаад байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.”							
9.	Арга хэмжээ 7.1. Олон улсын, бүсийн, гадаад байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлнэ.	Арга хэмжээний тоо	0	0	✓ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Сандра Шүфаниг 02 дугаар сарын сарын 27-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр Их өгөгдөл, хиймэл оюуны стратеги боловсруулахад Канад улсын талаас Техник эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх мөн Телесат Монгол сатын хамтын ажиллагааны санамж бичгийн хугацааг сунгах талаар санал солилцов. ✓ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү энэ сарын 15-ны өдөр Бүгд Найрамдах Энэтхэг улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Атул Малхари Готсурвег хүлээн авч уулзлаа. Монгол Улсын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг Энэтхэг улсад мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлд сургах, хоёр улсын мэдээллийн технологийн компаниудын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлд санал солилцов. ✓ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн дэд бүтэц хариуцсан захирал Судешна Гош Банержи, Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Таехюн Ли	01-06	90

					нарыг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр Монгол Улс хиймэл дагуултай болох, технологийн дэвшлийг нутагшуулах, дижитал шилжилт хийх зэрэг цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын томоохон асуудлуудад Дэлхийн банкны чадварлаг, туршлагатай мэргэжилтнүүдийн туслалцаа хэрэгтэй байгаа талаар дурдаад, дижитал шилжилтийн гурван тулгуур бодлогын нэгдүгээрт эрэмбэлэгдэж буй дижитал дэд бүтэц бий болгох чиглэлд хамтын ажиллагаа өрнүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлэв. ✓ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү өнөөдөр /2025.03.12/ БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь Миньжуан болон бусад албаны төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар талууд хоёр улсын шинжлэх ухаан, мэдээллийн технологийн салбарт хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах талаар санал солилцов.		
Зорилт 8. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.”							
10.	Арга хэмжээ 8.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу албан бичиг боловсруулна, шийдвэрлэнэ.	Боловсруулсан, шийдвэрлэсэн албан бичгийн тоо	-	30, 20	Тайлант хугацаанд Гадаад харилцааны яам руу 5 цахим шууданг бэлтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллав. Арга хэмжээ, сургалтад тэтгэлгээр оролцуулах 2 хүсэлтийг албажуулж хүргүүлсэн. Гадаад албан томилолтоор ажиллуулах 4 тушаалыг боловсруулан, албажуулав.	01-06	100
11.	Арга хэмжээ 8.2. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг архивд хүлээлгэн өгнө.	Архивд өгсөн баримт бичгийн тоо	-	4	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар батлагдсан 2024 оны гадаад томилолтын тайлан, гадаад явуулсан бичиг бүхий 3 боть хүлээлгэн өгсөн.	01-06	100

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6
НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ					
1.	Үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллах	Төрийн нарийн дарга	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/42 дугаар тушаалаар байгуулагдсан Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх 6 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллаж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд үр дүнгээ нийтлэн ажиллаж байна.	01-06	100
2.	Ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллах	Хэлтсийн дарга	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/42 дугаар тушаалаар байгуулагдсан Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программыг нэгдсэн зохион байгуулалттайгаар худалдан авах боломжийг судалж санал зөвлөмж боловсуурлах, нэгж лизензийн үнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулан тэмдэглэл хөтлөн саналуудыг нэгтгэн танилцуулан ажиллаж байна.	01-06	100
3.	Үнэлгээний хорооны гишүүн	Төрийн нарийн дарга	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/74, 2025 оны А/141 тус тус дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциатай хамтран хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг 2 төсөл”-ийн худалдан авах ажиллагааны “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгох” төслийн ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, мөн “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв байгуулах/тоног төхөөрөмж” төслийн тендерийг хянан үзэх,	01-06	100


		үнэлэхээр захиалагчид зөвлөмж хүргүүлэхээр үнэлгээ дүгнэлт гарган ажиллаж байна.		
--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Удирдлагын академийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр, албан тушаалын чиг үүрэгт хамаарах чиглэлээр дотоод, гадаадын сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан тоо	-	1	БНХАУ-ын Худалдааны яамнаас 2025 оны 04 дугаар сарын 10-наас 30-ны өдрүүдэд Чиндао хотноо зохион байгуулсан "Цахим худалдаа" чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.	01-06	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГХХАХ-ийн мэргэжилтэн
(Албан тушаал)

Н.Лувсаншарав /  /
(Нэр, гарын үсэг)

2025 06 09
(Огноо)